

д/д	Хөтөлбөрийн индекс	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн зорилго	Төгсөгчийн ажиллах гол ажлын байрууд
1	061203	Мультимедиа технологи	Мультимедиа технологийн чиглэлээр мэргэшсэн хөтөлбөрийн зорилго нь телевиз, кино судлал, сэтгүүл зүй, видео үйлдвэрлэл, интерактив медиа, компьютерийн анимэйшн гэх мэт медиа энтертайнмент, технологийн суурь мэдлэг, мэргэжлийн үндсэн чадваруудыг эзэмшихээс гадна орчин үед нэн шаардлагатай байгаа багаар ажиллах, харилцааны болон бүтээгдэхүүн, систем, үйл ажиллагааг бий болгох чадваруудыг эзэмшихэд оршино.	Мультимедиа дизайнер Видео эвлүүлэгч 2D/3D график дизайнер AR/VR хөгжүүлэгч Анимэйшн хөгжүүлэгч Студийн инженер Телевизийн инженер Дууны инженер Тоглоомын программист
2	061901	IoT /Юмсын интернэт/ технологи	Мэдээлэл холбооны инженерийн онолын суурь мэдлэг болон IoT технологийн ахисан түвшний суурь мэдлэг эзэмшсэн, мэдээлэл, холбооны инженер технологийн бүтээгдэхүүн, систем, үйл ажиллагааг хангах, зохион бүтээх, техник технологийн дэвшлийг судлан нэвтрүүлэх мэдлэг бүхий бүтээлч чадвартай, ёс зүйтэй, төлөвшсөн хандлагатай мэргэжилтнийг бэлтгэн гаргахад хөтөлбөрийн үндсэн зорилго оршино.	IoT технологи хөгжүүлэгч Электроник инженер Ухаалаг систем хөгжүүлэгч Сүлжээ төлөвлөлтийн инженер Мобайл программ хөгжүүлэгч Их өгөгдлийн шинжээч Технологийн зөвлөх IoT төслийн менежер IoT инновацийн менежер IoT программ хөгжүүлэгч Хөдөлгөөнт холбооны системийн инженер Судлаач зорион бүтээгч инженер Судалгаа шинжилгээний ажилтан

3	071407	Мэдээлэл холбооны сүлжээний инженерчлэл	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, хөтөлбөрөөр суралцаж, төгсөгчдөд олон улсын стандартын түвшинд мэдлэг, чадвар, хандлага эзэмших, хөтөлбөрийн чиглэлээр гадаадад ажиллах, нэр хүндтэй их сургуулиудад дэвшин суралцах өргөн боломжийг олгоход оршино.	Дамжуулах системийн инженер Холболтын системийн инженер Компьютерийн сүлжээний инженер Оптик системийн инженер Кабель шугамын инженер Хэрэглэгчийн сүлжээний инженер Ашиглалт үйлчилгээний инженер Өгөгдлийн төвийн ашиглалтын инженер Электроникийн инженер Хөдөлгөөн холбооны сүлжээний инженер Судлаач, зохион бүтээгч инженер Сүлжээ төлөвлөлтийн инженер Борлуулалт, үйлчилгээ хариуцсан инженер Судалгаа шинжилгээний ажилтан
4	071408	Утасгүй холбооны инженерчлэл	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, хөтөлбөрөөр суралцаж, төгсөгчдөд олон улсын стандартын түвшинд мэдлэг, чадвар, хандлага эзэмших, хөтөлбөрийн чиглэлээр гадаадад ажиллах, нэр хүндтэй их сургуулиудад дэвшин суралцах өргөн боломжийг олгоход оршино.	Хөдөлгөөн холбооны сүлжээний инженер Радио дамжуулах системийн инженер Сансрын холбооны сүлжээний инженер Өргөн нэвтрүүлгийн сүлжээний инженер Радио долгионы хяналтын инженер Радио холбооны системийн инженер Радио системийн ашиглалт үйлчилгээний инженер Судлаач, зохион бүтээгч инженер Судалгаа шинжилгээний ажилтан
5	061301	Компьютерын ухаан	Компьютерийн ухаан бакалаврын хөтөлбөрийн зорилго нь компьютерийн ухааны онол, хэрэглээний (ялангуяа Хиймэл оюун ба Биоинформатик) сайн боловсролыг олгох замаар мэргэжлийн, төрийн болон судалгааны байгууллагад бүтээлчээр ажиллах мэргэжилтэн бэлтгэх явдал юм.	Компьютерийн ухааны судлаач, өгөгдлийн шинжээч, дата аналит, бизнес шинжээч, өгөгдлийн архитектор, веб хөгжүүлэгч, веб дизайнер, программ хангамжийн хөгжүүлэгч, программист

6	061902	Хиймэл оюун ухаан	<p>Хиймэл оюун ухааны хөтөлбөрийн зорилго нь программ хангамж, техник хангамжийн системийг зохион бүтээхэд тулгарч буй асуудлуудад хиймэл оюуны арга аргачлал, алгоритм, загварыг боловсруулж хэрэгжүүлэх, онолын мэдлэг боловсролтой, мэргэжлийн, төрийн болон судалгааны байгууллагуудад бүтээлчээр ажиллах мэргэжилтэн бэлтгэх явдал юм.</p>	<p>Хиймэл оюуны шинжээч Ухаалаг бизнесийн шинжээч Хиймэл оюун хөгжүүлэгч Гүн сургалт хөгжүүлэгч Гүн сургалтын инженер Өгөгдлийн шинжээч Хиймэл оюун Хиймэл оюуны инженер Машин сургалтын инженер Компьютерийн харааны инженер ХО/Эх хэлний боловсруулалтын судлаач Эх хэлний боловсруулалтын инженер Эх хэлний боловсруулалтын хөгжүүлэгч</p>
7	071405	Программ хангамжийн инженерчлэл	<p>Программ хангамж бакалаврын ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО нь программ хангамжийн инженерчлэлийн онол, хэрэглээний сайн боловсролыг олгох замаар мэргэжлийн болон төрийн байгууллагад бүтээлчээр ажиллах мэргэжилтэн бэлтгэх явдал юм.</p>	<p>Глобал хөдөлмөрийн зах дээл дээр Software Engineering/Программ хангамжийн инженерчлэл бакалаврын хөтөлбөрт хамрагдсан төгсөгч нь мэргэжлийн байгууллагад Computer programmer (Компьютерын программ зохиогч), Software developer (Программ хангамж хөгжүүлэгч, дотроо системийн болон хэрэглээний ПХ хөгжүүлэгч, Mobile developers/аппликейшн хөгжүүлэгч гэж нарийсдаг), Applications architects (Программын архитектор), Computer systems analyst (Компьютерын системийн шинжээч), Database administrator (Өгөгдлийн сангийн админ), Software quality assurance engineer (ПХ-ийн чанарын баталгаажилтын инженер), Computer systems administrator (Компьютерын системийн админ) гэх мэтийн ажлын байранд ажилладаг. Мэргэжлийн бус байгууллагад компьютерын системийн ашиглалт, үйлчилгээний инженерээс эхлээд байгууллагын мэдээллийн технологийн хөгжлийн бодлогыг тодорхойлогч дээд түвшний удирдах ажилтан хүртэлх өргөн хүрээний ажлын байранд ажилладаг.</p>

8	071401	Электроникийн инженерчлэл	Электроникийн инженер технологийн чиглэлээр аливаа бүтээгдэхүүн, системийн инженерчлэлийн шийдлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах мэдлэг, шинжлэх ухааны шинэ технологи, чиг хандлагад үндэслэн судалгаа шинжилгээ хийх ур чадвар, бүтээлч сэтгэлгээтэй, багаар ажиллах болон бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх чадвартай инженерийг бэлтгэнэ.	Электроникийн инженер Автоматжуулалтын инженер Эмбэддэд системийн инженер Электрон системийг зохион бүтээгч Робот, эмбэддэд систем хөгжүүлэгч Электрон системийн програм хөгжүүлэгч Компьютерийн техникийн инженер Мэдээллийн технологийн инженер Профессор багш, судлаач, эрдэмтэн Зохион бүтээгч инженер Бүх салбарын мэргэшсэн инженер
9	078806	Робот ба хиймэл оюун ухаан	Ухаалаг удирдлагын системийн шийдлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион бүтээх мэдлэг, шинжлэх ухааны шинэ технологи, чиг хандлагад үндэслэн судалгаа шинжилгээ хийх ур чадвар, бүтээлч сэтгэлгээтэй, багаар ажиллах болон бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх чадвартай инженерийг бэлтгэнэ.	Робот системийн инженер Робот, эмбэддэд систем хөгжүүлэгч Робот системийн програм хангамжийн инженер Электроникийн инженер Автоматжуулалтын инженер Эмбэддэд системийн инженер Электрон системийг зохион бүтээгч Профессор багш, судлаач, эрдэмтэн Зохион бүтээгч инженер Бүх салбарын хиймэл оюун ухаан хөгжүүлэгч мэргэшсэн инженер
10	061201	Компьютерын сүлжээ	Мэдээллийн сүлжээний протокол, програм хангамж, тоног төхөөрөмж, техник технологийн талаар олон улсын жишгийн түвшинд мэдлэгтэй, мэдээллийн сүлжээний ашиглалт, үйлчилгээний ажлыг гүйцэтгэх, гэмтэл саатлыг илрүүлэн засах чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ.	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн байгууллагуудад IP сүлжээний инженер
11	061202	Кибер аюулгүй байдал	Кибер аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал, Системийн техник технологи, түүний хөгжил, удирдлага зохион байгуулалт төлөвлөлтийн арга зүйг эзэмшүүлж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт ашиглалт үйлчилгээг зохион байгуулах, тэдгээрийн удирдлага төлөвлөлтийг хийх чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ.	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн байгууллагуудад системийн аюулгүй байдлын, систем хамгаалал, компьютерийн систем хамгаалалын инженер зэрэг албан тушаалуудад ажиллах боломжтой.

12	061204	Өгөгдлийн ухаан	Өгөгдлийн ухааны хөтөлбөрөөр төгсөгч нь мэдээллийн технологи, компьютерийн ухаан, өгөгдлийн ухаан, математик, статистик шинжилгээний зарчмуудын талаар суурь мэдлэгийг эзэмшсэн их хэмжээний өгөгдлийг олон талаас нь задлан шинжилж, шийдвэр гаргахад туслах мэдээллийг олж илрүүлэх, төлөвлөлт хийх чадвартай болсон байна.	Өгөгдлийн инженер - Өгөгдлийн шинжээч -Статистикч - Хиймэл оюун ухааны инженер -Программист -Өгөгдлийн сангийн мэргэжилтэн
13	061303	Мэдээллийн систем	“Мэдээллийн систем” хөтөлбөрийн зорилго нь байгууллагын стратегийн зорилгод хүрэхийн тулд байгууллага болон түүнтэй хамтрагч байгууллагуудын мэдээллийн хэрэгцээг хангах, үр ашигтай, бүтээмжтэй мэдээллийн системийг хөгжүүлэх, сайжруулах, удирдах, аюулгүй байдлыг хангах, хамгаалах өндөр мэдлэг чадвар бүхий бакалавр зэрэгтэй, хөрвөх чадвартай, мэдээллийн системийн мэргэжилтэн бэлтгэхэд оршино.	Мэдээллийн системийн мэргэжилтэн, инженер - Системийн шинжээч, бизнес процессын шинжээч - Төслийн менежер, контент менежер - Программист - Өгөгдлийн сангийн администатор
14	061304	Мэдээллийн технологи	Мэдээллийн технологийн мэргэжлийн хөтөлбөрийн зорилго нь төгсөгч нь боловсрол, нийгэм, эдийн засгийн бүх салбарт ажиллах ба байгууллагын мэдээллийн технологийн бүхий л асуудлыг хариуцан төлөвлөх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх онолын болон практик ур чадвартай байхад оршино.	Мэдээллийн технологийн инженер - Системийн инженер -Үүлэн тооцооллын инженер - Сүлжээний админ - Төслийн менежер - Программист - Өгөгдлийн сангийн админ